



МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ
ОЛОН УЛС СУДЛАЛЫН ХҮРЭЭЛЭН

БНСУ-ЫН ЗАСГИЙН ГАЗРААС ҮНДЭСНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ, ЭКСПОРТЫГ ДЭМЖИЖ БУЙ ХЭЛБЭРҮҮД

Дашдаваагийн Мягмар
Эрдэм шинжилгээний ажилтан
myagmar_d@mas.ac.mn

Бүтэц

1. Оршил
2. Өмнө хэрэгжүүлсэн зарим бодлого хөтөлбөрүүд
3. Өнөөгийн байдлаар хэрэгжиж буй хөтөлбөр, үйлчилгээнүүд
4. Дүгнэлт, санал

Оршил

- Түүхий эдийн экспортын хараат байдлаас гарах
- Үндэсний үйлдвэрлэл, экспортыг хөгжүүлэх
- Өндөр хөгжилтэй орнуудын туршлагаас судлах
- БНСУ-ын үндэсний үйлдвэрлэл, экспортыг хөгжүүлсэн туршлага

Өмнө нь хэрэгжсэн бодлого хөтөлбөрүүд

- 1962-1992 он: 5 жилийн төлөвлөгөөт эдийн засаг
- 1960 он: Импортыг орлох өргөн хэрэглээний барааны үйлдвэрлэл
- 1970 оны Хүнд болон химийн аж үйлдвэрлэлийг дэмжих бодлого
- 1975 оны “Төвлөрсөн худалдаа эрхлэгч” хөтөлбөр
- 1979 оны Хэвтээ интеграцийн бодлого

Өмнө нь хэрэгжсэн бодлого хөтөлбөрүүд

Бодлогын үр дүн

Эхний үе шат: /1970-аад он хүртэл/ Улс орны санхүү эдийн нөхцөл сайнгүй, үйлдвэрлэлийн бааз суурь хөгжөөгүй байсан тухайн цаг үед аж үйлдвэрлэлийн дэд бүтэц, бааз суурийг бий болгон улмаар аж үйлдвэрлэлийг хөл дээр нь босгоход чиглэгдсэн.

Хоёрдугаар шат: /1970-2000 он гартал/ Олон улсын худалдааны орчин өнөө үетэй харьцуулахад төдийлөн тааламжтай бус, дотоод ААН-үүдийн гадаад худалдааны мэдлэг чадвар хомс байсан тухайн цаг үед гадаад худалдааны томоохон дэд бүтэцийг бий болгох замаар үндэсний үйлдвэрлэгчдийн экспортыг дэмжихэд чиглэгдсэн. /Корпорацид төвлөрсөн эдийн засаг/

Өргөн хэрэглээний барааны үйлдвэрлэл → Өргөн хэрэглээний барааны экспорт, завсарын

бүтээгдэхүүний үйлдвэрлэл → Завсарын бүтээгдэхүүн болон технологийн бүтээгдэхүүний экспорт.

Өнөөгийн байдлаар хэрэгжиж буй хөтөлбөр, үйлчилгээнүүд

Жижиг дунд үйлдвэрлэгчдийн экспортийг дэмжих бодлого

- Дотоодод чиглэсэн үйлдвэрлэгчдийг гадаад зах зээлд нэвтрүүлэх
- Экспорт хийдэг үйлдвэрлэгчдийн экспортын потенциалыг дээшлүүлэх

БНСУ-ын жижиг дунд бизнесийн ангилал

		Жижиг бизнес	Дунд бизнес
1	Борлуулалт (3 жилийн дундаж)	12 тэрбум воноос бага	150 тэрбум воноос бага
2	Нийт хөрөнгийн хэмжээ	500 тэрбум воноос бага	


Дэлхийн 59 улстай ЧХХ-ийн хүрээнд худалдаа хийдэг

Өнөөгийн байдлаар хэрэгжиж буй хөтөлбөр, үйлчилгээнүүд

БНСУ-ын баялаг бүтээх хэлбэр: Түүхий эдийг импортлох – Нэмүү өртөг шингээн үйлдвэрлэх – Эцсийн бүтээгдэхүүн экспортлох

- Үйлдвэрлэл худалдаа нөөцийн яам /ҮХНЯ/: Гадаад худалдаа, худалдааны хэлэлцээр, аж үйлдвэрлэл, түүхий эдийн нөөц бүрдүүлэх
- Жижиг дунд үйлдвэрлэгчдийн яам /ЖДҮЯ/: Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих, том болон жижиг, дунд бизнес эрхлэгчдийн хамтын ажиллагааг идэвхжүүлэх, үйлдвэрлэгчдийг хамгаалах

Өнөөгийн байдлаар хэрэгжиж буй хөтөлбөр, үйлчилгээнүүд



- Засгийн газар нь экспортыг дэмжих чиглэл болон санхүүжилтийн хэмжээг тодорхойлж хэрэгжүүлэгч байгууллагуудад хуваарилна
- Итгэмжлэгдсэн агентлагууд нь Засгийн газраас баталсан хөтөлбөрүүдийг гардан хэрэгжүүлнэ. Зарим төрлийн үйлчилгээг хувийн хэвшлийн мэрэгшсэн компаниудаар дамжуулан үйлдвэрлэгчдэд хүргэдэг.

Өнөөгийн байдлаар хэрэгжиж буй хөтөлбөр, үйлчилгээнүүд

Төрөөс үзүүлж буй дэмжлэг

- *Санхүүгийн*
- *Маркетингийн*
- *Технологийн*

Хилийн чанадад: КОТРА-гийн 83 улс дахь 128 салбар,
Солонгосын худалдааны хороо зэрэг байгууллагын гадаад дахь
салбарууд (зах зээлийн судалгаа хийх, бараа бүтээгдэхүүнийг
сурталчлах, харилцагчийн санхүүгийн чадварийг судлах...)

Дотоодод: Томоохон хотууд болон орон нутгийн салбаруудаад
дамжуулах хэрэгжүүлдэг бүх төрлийн үйлчилгээ

Өнөөгийн байдлаар хэрэгжиж буй хөтөлбөр, үйлчилгээнүүд

Санхүүгийн дэмжлэг

- Бодлогын санхүүжилт /ЖДҮЯ: 2023 онд 4,2 ихнаяд воны санхүүжилт/
- Татварын хөнгөлөлт, буцаан олголт, татаас
- Зээлийн баталгаа /Барьцаа хөрөнгөгүй үйлдвэрлэгчдэд зээлийн баталгаа гаргаж өгөх.../
- Худалдааны даатгал /Экспортын даатгал, импортын даатгал, валютын ханшийн өөрчлөлтийн эрсдэлээс хамгаалах даатгал.../

Өнөөгийн байдлаар хэрэгжиж буй хөтөлбөр, үйлчилгээнүүд

Маркетингийн дэмжлэг

- Дотоодын бараа бүтээгдэхүүнийг гадаад зах зээлд сурталчлан таниулах
- Үйлдвэрлэгчдэд гадаад худалдааны дэд бүтэц, борлуулалтын суваг бий болгох
- Компанийн ажилтнуудын гадаад худалдааны мэдлэг чадварыг дээшлүүлэх



ЖДҮЯ болон ҮХНЯ-наас 2022 онд Экспортын ваучер, Экспортын консорциум, Экспортын инкубатор, Онлайн экспортын платформ зэрэг 9 хөтөлбөр зарлаж үүнд 16.000 ААН-ийг хамруулжээ

Өнөөгийн байдлаар хэрэгжиж буй хөтөлбөр, үйлчилгээнүүд

Экспортын ваучер

Засгийн газрын бодлого хэрэгжүүлэгч агентлагуудын олон төрлийн үйлчилгээнээс бизнес эрхлэгч нь өөрийн эрхэлдэг бизнес, үйлдвэрлэлийн онцлогт тохирсон тодорхой тооны үйлчилгээг байгууллагын харьяалал харгалзахгүй багцлан сонгож авах үйл ажиллагаа.

- *2022 онд өмнөх жилийн тайлант хугацаанд 1 сая хүртэл долларын экспорт хийсэн үйлдвэрлэгчид 50 сая воны, 1-5 сая долларын экспорт хийсэн үйлдвэрлэгчид 70 сая воны ваучер олгосон.*
- *Экспортын ваучер үйлчилгээг авахын тулд ААН нь ваучерийн үнийн дүнгийн 30-50 хувийг төлөх ёстой.*
- *Экспортын ваучерийн багцад багтсан үйлчилгээ үзүүлэх боломжтой 2044 хувийн хэвшлийн байгууллага байна.*


№	Нэр	Дэлгэрэнгүй мэнү
1	Судалгаа, зөвлөгөө /Хууль, татвар, санхүүгээс бусад /	Хамтрагч, худалдан авагч, түүхий эд нийлүүлэлтийн суваг илэрүүлэх судалгаа, гадаад зах зээлийн судалгаа, хэрэглэгчийн судалгаа, өрсөлдөгч бүтээгдэхүүний судалгаа, гадаад компанийн санхүүгийн чадварын судалгаа. Менежментийн зөвлөгөө, байгууллагын дунд, урт хугацааны өсөлтийн стратеги төлөвлөх, экспортын стратеги төлөвлөх болон хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, гадаад зах зээлд нэвтрэх болон маркетингийн стратегийн зөвлөгөө гэх мэт.
2	Экспортод шаардлагатай орчуулга	Гэрээ, хууль, цахим контент, тоглоом/мобайл апп, бизнесийн болон технологийн баримт бичиг, цахим хуудас зэргийг орчуулах. Мөн бусад бүх төрлийн аман орчуулгын үйлчилгээ.
3	Экспортын чадварыг дээшлүүлэх сургалт	Худалдаа, глобал маркетинг, бизнесийн ярилцлага, зорилтот зах зээлд нэвтрэх, Хятадын зах зээлийн цахим сургалт, байгууллагын дотоод чадварыг дээшлүүлэх, стратегийн бүтээгдэхүүн, худалдааны баримт бичгийн мэргэжилтэн бэлтгэх, глобал бизнесийн мэргэжилтэн бэлтгэх, гадаад зах зээлд нэвтрэх процесс, оюуны өмчийг бүртгүүлэх, оюуны өмчийн маргаан зохицуулах зэрэг сургалт.
4	Тусгай зөвшөөрөл, оюуны өмчийн гэрчилгээ авах, шалгалтад хамрагдах	Тухайн улсад оюуны өмчийг бүртгүүлэх, тусгай зөвшөөрөл, батламж болон импортын зөвшөөрөл авах стратегийн зөвлөгөө, оюуны өмчийн маргаанд туслах, AEO (authorized economic operator) буюу худалдааны хүлээн зөвшөөрөгдсөн компанийн гэрчилгээ авахад туслах зэрэг үйлчилгээ.
5	Экспортын бичиг баримт боловсруулах, бүртгүүлэх, валют арилжааны даатгал	Гэрээний драфт бэлдэх. Гааль, тээвэр, төлбөрийн бичиг баримт, ЧХХ-ийн гарал үүсэлтэй холбоотой баримт бичиг, мөн цахим худалдаатай холбоотой баримт бичиг боловсруулах. Тухайн улсад хуулийн этгээд байгуулах, бүртгүүлэх, мөн худалдааг төлөөлөн хийх, засгийн газрын худалдан авалтад оролцох, валют арилжааны даатгалд хамрагдахад туслах зэрэг.
6	Компани, бүтээгдэхүүн, брэндийг гадаадад таниулах	Компани, бүтээгдэхүүн, брэндийн сурталчилгааг телевиз, сонин, сэтгүүлээр хийх. SNS, search engine marketing, viral marketing, internal marketing communication зэрэг маркетинг сурталчилгааны арга хэрэгслүүдийг ашиглана.
7	Экспортын брэндийг хөгжүүлэх	Экспортын брэнд, онлайн болон оффлайн хэлбэрийн барааны танилцуулга бэлдэх, брэндийн баталгаажуулалт хийх, хуурамч үйлдвэрлэлээс сэргийлэх зэрэг.
8	Үзэсгэлэн худалдаа, арга хэмжээнд хамруулах	Дотоодод болдог олон улсын үзэсгэлэн худалдаанд хамруулж гадаад худалдан авагчтай уулзуулах, семинар, бүтээгдэхүүний танилцуулгад хамруулах. Гадаад худалдан авагчийг урьж ирүүлэн уулзуулах болон бүтээгдэхүүн танилцуулах, семинар хийх. Гадаадын төсөлд хамрагдахад дэмжлэг үзүүлэх зэрэг.
9	Хууль, татвар, санхүүгийн зөвлөгөө	Аудит, санхүүгийн шалгалт, санхүүгийн зөвлөгөө, хуулийн зөвлөгөө, хуулийн этгээд байгуулах. Гадаад улсад үүссэн маргаан таслахад туслах, гадаадад хуулийн этгээд байгуулах зэрэг экспорттой холбоотой зөвлөгөө.
10	Дизайн хөгжүүлэлт	Гадаад хэл дээрх танилцуулга, цахим каталоги бүтээх, гадаад хэл дээрх савлагааны загвар гаргах, гадаад хэл дээрх цахим хуудас хийх, цахим апп бүтээх, гадаад онлайн цахим худалдаанд хуудас нээх, бүтээгдэхүүний загвар гаргах, компанийн болон бизнесийн танилцуулга хийх.
11	Видео танилцуулга	Гадаад зах зээлд нэвтрэхэд шаардлагатай дүрс бичлэгэн танилцуулга сурталчилгаа бүтээх.
12	Гадаадын стандартын шалгуур	Импортын стандартын баталгаажуулалтын зардлыг төлөх. Эрүүл ахуй аюулгүй байдал, халал зэрэг импортлогч талын стандарт шалгуурыг хангах, импортын зөвшөөрөл авахад туслах үйлчилгээ.
13	Олон улсын тээвэр	Далайн болон агаарын тээврийн зардал, даатгалын төлбөрөөс хөнгөлөх /дотоодод болон импортлогч улсад гарах зардал/

<https://www.exportvoucher.com/>

Экспортыг ваучер хөтөлбөрийн хүрээнд зар сурталчилгаа, видео контент хийх үйлчилгээ үзүүлдэг Connect Wave компанийн статистик үзүүлэлт.

Үүнд:

- Ямар төрлийн үйлдвэрлэгчид уг компанийн үйлчилгээг сонгодог
- Уг компанийг сонгосон үйлдвэрлэгчдийн экспортын түвшин /Экспортлогч, анхлан экспортлогч дотоод зах зээлд бараа нийлүүлэгч/
- Аль улс руу экспорт хийхэд тусалдаг
- Үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин



Өнөөгийн байдлаар хэрэгжиж буй хөтөлбөр, үйлчилгээнүүд

Технологийн дэмжлэг

Зорилго: Үйлдвэрлэл үйлчилгээний технологийг сайжруулах замаар бүтээмж, өрсөлдөх чадварыг сайжруулж, экспортын хэмжээг нэмэгдүүлэх

1. Туршилт, судалгаа хөгжүүлэлтийг дэмжих
2. Шинэ технологид зээл олгох: Технологийн баталгааны сан
3. Түүхий эдийн нөөц бүрдүүлэх: Байгаль орчин, уул уурхайн корпорац
4. Бүтээгдэхүүнийг импортлогч улсын стандарт шалгуурт нийцүүлэхэд туслах: Химийн туршилт судалгааны хүрээлэн /CE, NRTL, RoHS зэрэг 160 орчим төрлийн стандарт/.
5. Худалдан авалтыг дэмжих захиргааны арга: Төрийн худалдан авалтын 50 буюу түүнээс дээш хувь нь ЖДҮ-ийн бараа бүтээгдэхүүн, түүний 15-аас дээш хувь нь технологийн бүтээгдэхүүн байх. Солонгосын Засгийн газрын хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжаар т/т нийлүүлэх
6. Мэдээллийн технологийн компаниудын экспортыг дэмжих: АНУ-ын цахиурын хөндий болон Япон, Хятад дахь МТ-ийн экспортыг дэмжих төв. AI EXPO, IT EXPO, ICT convergence Korea

Дүгнэлт, санал

- Төрийн бодлого хөтөлбөрүүд нь үйлдвэрлэгчдэд зах зээлийн орон зай гаргаж өгөхөд чиглэгдэж байна.
- Бодлого хэрэгжүүлэх чиг үүрэгтэй байгууллага хоорондын уялдаа холбоо сайн
- Хөтөлбөрт хамрагдах процесс цахимжсан, бизнес эрхлэгчдэд түвэг чирэгдэл бага
- Хэрэгжүүлэгч агентлагуудын тууштай байдал нь салбартаа мэргэшиж, туршлага хуримтлуулах, өндөр амжилт олох үндэс болж байна.
- Засгийн газар шаардлагатай мэдээллийг хувийн хэвшлээс гаргуулж авах эрх хуульчлагдсан байдаг, мөн эрдэм шинжилгээний байгууллагуудтай ойр хамтран ажилладаг
- Экспортыг дэмжих агентлагууд болон үйлчилгээ нь маш олон төрөл болж тэдний дунд өрсөлдөөн бий болсон
- Цаашид БНСУ-ын экспортыг дэмжих хөтөлбөр, хэрэгжүүлэгч байгууллагуудыг нарийвчлан судлах шаардлагатай